



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН /БАГ/, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

2021. 7. 20 № 03 /1748
танай _____-ны № _____-т

Шинжээч сонгон шалгаруулах зар хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам барих төслийн зураг төсөл, төсөв, ажлын гүйцэтгэлд шинжээчийн дүгнэлт гаргах” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээч нь дээрх төслийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилгын норм дүрэм, журам бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргах ба, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар болон концесс эзэмшигч “Макс рөүд” ХХК болон “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн эрх бүхий байгууллага, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулж, бэлтгэгдсэн ажлын баримт материал, нотлох зүйлсэд үндэслэн төслийн байршил дээр үзлэг шалгалт хийх, ажлын тоо хэмжээг тулгах, дүн шинжилгээ, тооцоолол хийнэ.

Тус зөвлөх үйлчилгээг 3 хүртэл сарын хугацаанд гүйцэтгэх ба концессын гэрээгээр хэрэгжсэн төслийн зураг төсөл, төсөв, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан эсэх, барилга байгууламжууд зураг төсөл, техникийн шаардлагын дагуу баригдсан эсэхийг хянан үзэж, шинжээчийн дүгнэлт гаргахын зэрэгцээ, шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны үр дүнг тусгасан шинжээчийн тайлан бичиж аудитын багт хүлээлгэн өгнө.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр
/2018,2019,2020 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2019, 2020 оны

Z:\Yawsan Bichid\2021\0719CXX5.Docx

001053153

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/;

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

Шинжээчийн ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүнд авто замын барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд байх ба шинжээчээр ажиллах боловсон хүчин нь салбартаа мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан зөвлөх зэрэгтэй инженер, эсхүл тэргүүлэх төсөвчин, эсхүл зөвлөх эдийн засагч зэрэгтэй байх. Үүнд:

- Автозамын инженер;
- Авто замын зураг төсөл боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй;
- Авто замын барилга угсралтын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй;
- Авто замын болон хиймэл байгууламжийн /гүүр, ус зайлуулах хоолой/ төсөв боловсруулах, хянах, магадлал хийх эрхтэй, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин:


Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. /Гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үүргийг тусгасан байна/

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 17 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутын дотор цахим /pdf файл/ хэлбэрээр дараах хаягаар илгээнэ үү.

Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068. Хугацаа хоцроосон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33. www.audit.mn.

ТАМГЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД